

 ГОЛОМТ БАНК

ТОГТВОРТОЙ,  
НОГООН  
САНХҮҮЖИЛТИЙН  
САЙН ТУРШЛАГУУД  
2024





MEMINGCV

GOLONT BANK

G

# АГУУЛГА

<b>ГОЛОМТ БАНКНЫ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ</b>	<b>4</b>
<b>Таксономийн ангилал 1. Сэргээгдэх эрчим хүч</b>	<b>6</b>
Хидро инженеринг ХХК	6
<b>Таксономийн ангилал 2. Бохирдол багатай эрчим хүч</b>	<b>7</b>
Горгаз ХХК	7
<b>Таксономийн ангилал 3. Эрчим хүчний хэмнэлт</b>	<b>10</b>
Шилэн хийц ХХК	10
Драгон холдинг ХХК	12
Монос фарм ХХК	14
Ерөнхий боловсролын жаргалан сургууль НҮТББ	16
Эмжж ХХК	18
<b>Таксономийн ангилал 5. Бохирдлоос сэргийлэх бууруулах үйл ажиллагаа</b>	<b>20</b>
Ам та тү ХХК	20
<b>Таксономийн ангилал 6. Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ</b>	<b>22</b>
Электрокем монгол ХХК	22
Цэцүүх трейд ХХК	24
Полипак ХХК	26
Мультипак ХХК	28
<b>Таксономийн ангилал 8. Карбон бага ялгаруулдаг тээвэр</b>	<b>30</b>
Говь күрүма ХХК	30
<b>ГОЛОМТ БАНКНЫ НОГООН ЗЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА</b>	<b>32</b>
Global climate partnership fund (GCPF)	33
Water equity (WE)	34
<b>ГОЛОМТ БАНКНЫ НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>35</b>







ГОЛОМТ БАНКНЫ  
ТОГТВОРТОЙ  
САНХҮҮЖИЛТ





## ГОЛОМТ БАНКНЫ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр, Санхүүгийн Санаачилгаас гаргасан банкны салбарын нөлөөллийн шинжилгээний аргачлалыг ашиглан зээлийн багцын байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлсон. Уг ажлын хүрээнд нийт зээлийн багцын 32% нь усны хомсдол болон 47% нь уур амьсгалын өөрчлөлтөд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа ба Голомт банк нь энэхүү байгаль орчны асуудлуудад онцгойлон анхаарч, бууруулах дунд болон урт хугацааны зорилтуудыг тавин хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

### Голомт банкны зорилтууд:


Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:  
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

2030 онд ↓30%



Тогтвортой усны менежментийг дэмжих:  
Ус дахин ашиглах, саарал ус дахин боловсруулах шилжилтийг дэмжих

2030 онд ↓5%



2020 оноос Монгол Улсын Ногоон Таксономийн хэрэгжилтийг ханган ногоон тогтвортой зээлийн багцыг ангилан бүрдүүлэхээс гадна 6 төрлийн хөнгөлөлттэй тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж 2019-2023 оны хооронд 565 тэрбум төгрөг, үүнээс 2023 онд 243 тэрбум төгрөгийн тогтвортой ногоон зээл шинээр олгосон байна.

2020 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг ногоон, тогтвортой зээлийн багцаар бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

### ХИДРО ИНЖЕНЕРИНГ ХХК

#### Компанийн танилцуулга:



“Хидро-Инженеринг” ХХК нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, усны барилга байгууламж, ус хангамж, ариутгах татуурга болон инженерийн хийцтэй барилга, байгууламжийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулах болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мониторинг хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан аж ахуйн нэгж юм.





## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Төвийн цахилгаан станцаас алслагдсан бүс нутагт нарны эх үүсвэрээр эрчим хүч үйлдвэрлэх панел суурилуулах эргэлтийн хөрөнгийн зээл

### Төслийн мэдээлэл:

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт хэрэгжих "Байгаль орчноо хамгаалах загас үржүүлэх загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийн судалгааны ажлын хүрээнд төсөл хэрэгжих байршил нь эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс алслагдмал бүс нутагт байрлах тул цахилгаан болон дулааны эрчим хүчийг нарны эх үүсвэрээр шийдвэрлэх нь зохистой гэж үзжээ. Улмаар харилцагч компани нь уг төсөлд нийт 80ш 500Вт-ын нарны дэлгэцийг суурилуулах ажлыг гүйцэтгэлээ.

### Таксономи ангилал:

1.2.2 Жижиг хэмжээний нарны цахилгаан үүсгүүр

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 40 КВТ/ЦАГ

Суурилуулсан нийт хүчин чадал

## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 2. БОХИРДОЛ БАГАТАЙ ЭРЧИМ ХҮЧ

### ГОРГАЗ ХХК

#### Компанийн танилцуулга:



“Горгаз” ХХК нь 2003 онд байгуулагдсан бөгөөд эдүгээ хийн түлшний салбарт тасралтгүй 20 жил үйл ажиллагаа явуулаад буй аж ахуйн нэгж юм. Харилцагч байгууллага нь ОХУ-ын “Роснефть” компанийн Монгол улс дахь албан ёсны гэрээт борлуулагч бөгөөд эдүгээ хийн түлшний зах зээлийн 30 гаруй хувийг дангаар хангаж байна.





## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй цэцэрлэг, сургууль, төрийн байгууллагын нам даралтын зуухыг хийн зуухаар солих зээл

### Төслийн мэдээлэл:

“Горгаз” ХХК нь “Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлаж буй төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй сургууль, цэцэрлэг, төрийн байгууллагын нам даралтын зуухыг хийн зуухаар солих” төслийн хүрээнд нийслэлийн 152-р сургууль, 148-р сургууль болон 109-р сургуулиудын нам даралтын зуухыг хийн зуухаар сольж суурилуулжээ. Тус хийн зууханд ашиглагдах шингэрүүлсэн хийн түлш нь шаталтын дулаан өндөртэй, үл шатах үлдэгдэл багатай, орчныг бохирдуулдаггүй эрчим хүчний цэвэр эх үүсвэр юм. Улмаар төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй сургуулиуд нь нүүрсний оронд хийн түлш ашиглан дулаан болон цахилгаан үйлдвэрлэх боломжтой болжээ. Тус цэвэр эрчим хүчний шийдэл бүхий төсөл нь төсөл хэрэгжихээс өмнө жил бүр хэрэглэдэг байсан 2645 тн нүүрсний хэрэглээг халж, 1091 тн үнсний хаягдал үүсэхээс сэргийлж чадсан байна.

### Таксономи ангилал:

2.2.1 Хийн түлш ашиглан цахилгаан болон дулаан үйлдвэрлэх

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 26,272PPM CO2-Г 36PPM CO2

Жилд хэрэглэж буй нүүрснээс ялгарах 26,272ppm CO2-г 36ppm CO2 болгож буурууллаа.



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

### ШИЛЭН ХИЙЦ ХХК

#### Компанийн танилцуулга:



### ШИЛЭН ХИЙЦ

Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартыг нэвтрүүлснээр бүтээгдэхүүн бүрийг чанарын нарийн хяналт дор үйлдвэрлэж, гологдол хаягдлыг бууруулан, цаашид бүрэн робот автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон орчин үеийн жишиг үйлдвэр болохоор төлөвлөж байна. Одоогоор нийт 16 бүлэг бүхий 607 нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж байна.

“Шилэн Хийц” ХХК нь шил боловсруулах, шилэн эдлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр анх үйл ажиллагаагаа 2002 онд эхлүүлж байсан. Байгууллагын үйл ажиллагаа өргөжиж вакум хаалга цонх, нарны цахилгаан үүсгүүрийн үйлдвэрлэл зэрэг чиглэлээр салбар компаниуд үүсгэн амжилттай ажиллаж байна. “Шилэн Хийц” ХХК нь 100% дотоодын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан үндэсний компаниудын нэг юм.



Шинэ тоног төхөөрөмж, шинэ технологийг үйлдвэрлэлд байнга нэвтрүүлж ирснээр өдгөө зах зээлийн 50% орчим хувийг чанартай шил, шилэн бүтээгдэхүүнээр хангагч, салбартаа тэргүүлэгч үйлдвэр болоод байна. 2020 онд Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэгт шинэ үеийн хагас автомат бүрэн тоног төхөөрөмж бүхий үйлдвэрийг барьж ашиглалтад оруулсан ба нийт 114 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.





## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Шилэн бүтээгдэхүүний үйлдвэрт эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж худалдаж авах зээл

### Төслийн мэдээлэл:

Шинээр худалдаж авах тоног төхөөрөмж нь импортын хамаарлыг багасгаж, богино хугацаанд захиалга гүйцэтгэх, бүтээгдэхүүний нэр, төрлөө олшруулах боломжийг бий болгоно. Ингэснээр Монгол улсын эрчим хүчний хэмнэлтийн хуулийн хүрээнд хаалга цонх, шилэн фасадын MNS стандартуудыг бүрэн хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, металл хаалга, цонх үйлдвэрлэдэг жижиг дунд үйлдвэрүүдийг түүхий эд материалаар хангах нөхцөл бүрдэнэ.

### Таксономи ангилал:

3.1.1 Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж болон технологийн сайжруулалт

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 30%

Эрчим хүчний хэрэглээ 30%-р багасна

# 40-50%

Шил хатжуулах бүтээмж 40-50% нэмэгдэнэ

# 96.36TnCO2E

Бууруулах хүлэмжийн хийн хэмжээ (жилд тнCO2e) : 96.36 тнCO2e/эрчим хүчний хэрэглээнээс



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

### ДРАГОН ХОЛДИНГ ХХК

#### Компанийн танилцуулга:



“Драгон Холдинг” ХХК нь анх 1993 оноос “Луу 3” ХЭАА, 1996 оноос “Дөрвөн луу” ХХК, 2008 оноос “Драгон Холдинг” ХХК нэртэйгээр өөрийн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. “Драгон Холдинг” ХХК нь байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсаар ирсэн. “Драгонхолдинг ХХК” нь 2015 онд одоогийн 7 давхар шилэн Драгон төвийг ашиглалтад оруулснаар бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн ба 800 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Эрчим хүчний хэмнэлттэй “Зорчигч тээврийн терминал” үйлчилгээний цогцолбор барих хөрөнгө оруулалтын зээл

### Төслийн мэдээлэл:

“Шинэ Улаанбаатар Баруун Терминал”/New Ulaanbaatar West Terminal/ Сонгинохайрхан дүүргийн 29-р хороонд байрлах “Драгон Холдинг” ХХК-ийн барьж буй “Шинэ Улаанбаатар Баруун терминал” цогцолбор. Уг цогцолбор нь 6 давхар бүхий зорчигч тээврийн терминал, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, худалдаа үйлчилгээ болон энтертайнмент төвийг төлөвлөсөн 6 блокоос бүрдэнэ. Төсөл хэрэгжсэнээр Монгол улсын баруун бүсийн 16 аймгийн 54 чиглэлд улс, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид болон нийслэлийн иргэд тав тухтай, сэтгэл хангалуун үйлчилгээ авах нөхцөл бүрдэх юм. Энэхүү бүтээн байгуулалт нь 545 автомашины зогсоол, 33 автобусны зогсоол, 36 хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоол бүхий олон улсын стандартад нийцсэн Монголын анхны улс, хот хоорондын зорчигч тээврийн цогцолбор болох юм. Олон улсад мөрдөгддөг “facility management” буюу үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын менежментийг хэрэгжүүлснээр тус орчны хөрсний бохирдол, тоосжилт, хог хаягдлын асуудал бүрэн шийдэгдэнэ.

### Таксономи ангилал:

3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 28%

Эрчим хүчний хэмнэлтийн хувь: 28%

# 422ТНСО2Е

Бууруулах хүлэмжийн хийн хэмжээ (жилд тнCO<sub>2</sub>e) : 422тнCO<sub>2</sub>e/эрчим хүчний хэрэглээнээс

# 4-6 ТЭРБУМ

Улс, нийслэл, дүүргийн татвар бүрдүүлэхэд жилд 4-6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.

# 10%

Терминал төвийг олон улсын жишигт нийцүүлснээр гадаадын жуулчлал 10%, дотоодынх 23%-р нэмэгдэнэ.

# 1800

# АЖЛЫН БАЙР

Шинээр 1800 ажлын байр бий болно.





## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

### МОНОС ФАРМ ХХК

#### Компанийн танилцуулга:



Монос Групп компани Монгол Улсад анхны 10 хувийн хэвшлийн нэг болж 1990 онд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. Монос Групп компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн анхны гэсэн тодотголтой хувийн эм, гоо сайхны үйлдвэр, эмийн сан болон өөртөө үйлчлэх эмийн сан, сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Монос Эмийн Үйлдвэр нь эм үйлдвэрлэлийн Олон Улсын GMP стандартад нийцсэн Эмийн Үйлдвэр, Чанарын Удирдлагын

Тогтолцоо ISO9001, Магадлан итгэмжлэгдэж ISO 17025 стандартыг хангасан Эм бэлдмэлийн сорилтын лаборатори, Эм зүйн судалгаа шинжилгээгээр дагнасан Эм Судлалын Хүрээлэн, Ургамал тарималжуулах Ботаник цэцэрлэг бүхий үндэсний жишиг үйлдвэр юм. Нийтдээ 80 гаруй нэр төрлийн эм бэлдмэлээс 30 гаруй нь тус компанийн брэнд бүтээгдэхүүн бөгөөд Монгол Улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 25 гаруй нэр төрлийн эмийг үйлдвэрлэдэг.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

GMP эмийн үйлдвэрийн барилга барих зээл

### Төслийн мэдээлэл:

Монос ХХК нь GMP – 3 ургамлын гаралтай эмийн үйлдвэрийн барилгын ажлын санхүүжүүлэх хүсэлт өгсөн ба тухайн барилга нь барилгын эрчим хүчний 20%-ийн хэмнэлтийн гэрчилгээтэй. Олон улсын жишигт нийцсэн эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр барьснаар үйл ажиллагаа тэлж, гадны зах зээлд эдийн засгаа тэлэх боломжтой болох юм.

### Таксономи ангилал:

3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 20%

Эрчим хүчний хэмнэлт

# 32.73TnCO2E

Ялгарахаас сэргийлж буй карбон (жилд тнCO2e) : 32.73 тнCO2e/эрчим хүчний хэрэглээнээс

## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЖАРГАЛАН СУРГУУЛЬ НҮТББ

### Компанийн танилцуулга:

Баянзүрх дүүргийн 20-р хорооны Шар хоолойн аманд байрлах Green school of Mongolia нь нэг ээлждээ 15 танхимд 240 хүүхэд хичээллэх хүчин чадал бүхий ерөнхий боловсролын сургууль юм. Сургууль нь олон төрлийн эмийн ургамал, жимс жимсгэнэ ургадаг газарт гол горхи, олон төрлийн шилмүүст болон навчит модоор хүрээлэгдсэн цэвэр, эрүүл агаарт байршилтай нь сурагчдын эрүүл мэндэд оруулж буй томоохон хөрөнгө оруулалт болж байна.

Хөтөлбөрийн хувьд хүүхдэд зориулсан стеам робот, адал явдал, танин мэдэхүй, ногоон боловсрол, сэтгэлзүй, Монголын өв соёлоо тээх, түгээн дэлгэрүүлэх зэрэг 100 гаруй хөтөлбөртэй бөгөөд экологийн боловсрол олгох хүлэмждээ ногоо тариалж, тухайн үйл ажиллагаанд сурагчдын оролцоог хангахын сацуу шим тэжээл бүхий ургацаа хоол хүнсэндээ ашигладаг.

Сургуулийн барилгын шийдэл нь эрчим хүчний хэмнэлттэй бөгөөд нийт 22 хувийн эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээтэй юм.





## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Ерөнхий боловсролын сургуулийн эрчим хүчний хэмнэлттэй барилга барих хөрөнгө оруулалтын зээл

### Таксономи ангилал:

3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 60.17TnCO2E

Эрчим хүчний хэмнэлттэй барилга нь жилд 60.17TnCO2e ялгарахаас сэргийлнэ.

# 22%

Эрчим хүчний хэмнэлт 22%

# 240 ХҮҮХЭД

240 хүүхэд хичээллэх хүчин чадалтай

## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

### ЭМЖЖ ХХК

#### Компанийн танилцуулга:



ЭМЖЖ эмнэлэг нь анх 1993 онд үүсгэн байгуулагдсан ба одоогийн байдлаар мэс засал, хэвтүүлэн эмчлэх 41 ортой, үзлэгийн 8 амбулаторитой, чих хамар хоолой, сонсголын нарийн мэргэжлийн шинжилгээ, оношилгоо, сонсголын аппаратын тохируулга, засвар үйлчилгээг хийж, 2017 онд тэнцвэрийн шинжилгээний иж бүрэн кабинетыг байгуулан 260 гаруй ажилтантай болж, чих хамар хоолой, сонсгол, тэнцвэр судлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлж, үйл ажиллагаагаа явуулдаг.

Мөн ЭМЖЖ эмнэлэг нь ХБНГУ, БНСУ, Итали улс, Тайван улс, БНХАУ, ОХУ зэрэг олон улстай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, гадаад харилцаагаа бэхжүүлж, эмч, мэргэжилтнээ сургах, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий багаж, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ, оношилгооны шинэ арга зүйг монгол улсад оруулж ирж, нутагшуулах зэргээр Монгол улсын чих хамар хоолойн салбарт томоохон хувь нэмрээ оруулан ажилладаг.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Дулаалга болон эрчим хүчний үр ашгийг 80 хувиар нэмэгдүүлэх зээл

### Таксономи ангилал:

3.3.2 Одоо байгаа арилжааны, нийтийн, орон сууцны болон үйлдвэрлэлийн барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:



# 79.1%

Барилгын засвар, сайжруулах ажлын хүрээнд улиралд зарцуулах эрчим хүчний хэрэглээг 79.1 хувиар бууруулсан.



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### АМ ТА ТҮ ХХК

#### Компанийн танилцуулга:



"Ам та тү" ХХК нь Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт 26.85 га талбай бүхий тусгай зөвшөөрөлтэй Аралт худаг нэртэй шохойн чулууны орд газрыг эзэмшдэг.

Тухайн уурхай нь жилд 30 мянган тонн шохойн чулуу олборлох хүчин чадалтай ба Аралт худаг ордыг түшиглэн Шохой боловсруулах үйлдвэртэй бөгөөд жилд 20 мянган тонн шохой үйлдвэрлэдэг.

"Ам Та Тү" ХХК нь өөрийн эзэмшлийн ордыг түшиглэн үйлдвэрлэсэн шохойг Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг "Шинь Шинь" ХХК-ийн уулын баяжуулах үйлдвэр, мөн аймгийн Цагаан-Овоо сумын нутагт "Степ голд" ХХК-ийн Алтан цагаан овоо төсөлд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Тоног төхөөрөмж сайжруулалтын зээл

### Төслийн мэдээлэл:

Үйлдвэр нь үндсэн хүчин чадлын хүрээнд шохойн чулуу шатаан боловсруулж шохой гаргаж авах үйл ажиллагаанд жилд 14,341 тн нүүрс хэрэглэдэг байсан ба тоног төхөөрөмж шинчлэн сайжруулснаар нүүрсний хэрэглээг 9,741 тн болгон бууруулсан. Ингэснээр шохой боловсруулах үйлдвэрт нэн шаардлагатай нүүрсний зардлыг хэмнэснээр 1 тн шохойн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртөг буурах боломжтой.

### Таксономи ангилал:

5.1.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах, дахин боловсруулах байгууламжууд

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 17,389ТНСО2Е

Шинэ тоног төхөөрөмжтэй үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд 54 хувиар нүүрсний хэрэглээ багасаж жилд 17,389 тнСО2е агаар мандалд ялгаруулахаас сэргийлж байна.

## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ

### ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК

#### Компанийн танилцуулга:



“Электрокем Монгол” ХХК нь хар тугалган батареийг байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи ашиглан дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж юм.



#### БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

### 30 ОРЧИМ

Бусад ижил төстэй үйлдвэртэй харьцуулахад даруй 30 орчим хувийн бага дулаан, цахилгааны эрчим хүч зарцуулдаг.

### 340,000Ш

Жилд 340,000 ширхэг батареий боловсруулах хүчин чадалтай ба жил бүр энэ хэмжээгээр үүсэх хаягдлыг үгүй болгож байна.

### 33 АЖЛЫН БАЙР

Үйлдвэр нь шинээр 33 ажлын байрыг бий болгож байна.

### 1,000 ТН

Жилд 1,000 тн хүхрийн хүчлийн уусмал хаягдахаас сэргийлнэ,



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Хар тугалганы батарей дахин боловсруулах үйлдвэр барих хөрөнгө оруулалтын зээл

### Төслийн мэдээлэл:

Хар тугалганы батарей дахин боловсруулах үйлдвэр

Хар тугалганы батарей нь найрлага дахь хар тугалга болон хүхрийн хүчлээс шалтгаалан ашиглаж дууссаны дараа олон улсад аюултай хог хаягдалд тооцогддог тул дэлхий дахинаа ашиглалтаас гарсан хар тугалган батарейны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөс сэргийлэх, хянах үндсэн арга нь батарейг дахин боловсруулах гэж үздэг.

Хар тугалга нь хүний биед бага багаар хуримтлагддаг онцлогтой хорт бодис бөгөөд мэдрэл, хоол боловсруулах, зүрх судас болон бөөрний үйл ажиллагааны системийг хордуулдаг. Бага насны хүүхэд хар тугалганы бохирдолд илүү өртөмтгий байдаг нь тэдний аж байдал, үйл хөдлөлтэй шууд холбоотой байдаг.

Дэлхий даяар нийт хар тугалганы хэрэглээний 86 орчим хувийг моторт тээврийн хэрэгсэлд ашигладаг батарей үйлдвэрлэл болон салхин турбинаас гаргаж авсан эрчим хүчийг хадгалахад зарцуулдаг байна. Иймд харилцагч компани нь хар тугалганы батарейг дахин боловсруулах 3,522 мкв талбай бүхий үйлдвэрийг МУ-ын MNS 6783:2019 стандарт болон олон улсын шаардлагад бүрэн нийцэх технологиор барьсан бөгөөд жилд 800,000 ширхэг буюу 12,000 тонн батарейг дахин боловсруулах хүчин чадалтай ажээ. Үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад МУ-д хаягдаж буй нийт хаягдал хар тугалганы батарейг 100% боловсруулах боломжтой нь хар тугалганы бохирдлыг бууруулах томоохон алхам болж байна. “Электрокем Монгол” ХХК дахин боловсруулах үйлдвэрийн хувьд батарейг бутлан ангилах технологийн явцад бий болох хүхрийн хүчлийн ууршилтыг үйлдвэрийн дотоод орчин болоод байгальд алдагдахаас сэргийлж бүрэн битүүмжилсэн тоноглол бүхий, шүүгч системийг ашиглан саармагжуулдаг ба пирометалургийн аргаар хайлуулах үйл ажиллагааны явцад ялгарах халуун, хортой, хар тугалганы тоосонцор агуулсан утаа тортог бүхий утааг 7 төрлийн тоног төхөөрөмжийн дамжлага бүхий бохирдол барих системээр шүүн цэвэрлэж МУ болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан цэвэршүүлсэн хийг агаарт нийлүүлдэг. Түүнчлэн, үйлдвэр нь технологийн хаягдалгүй, хэрэглэсэн усаа цэвэршүүлж үйл ажиллагаандаа дахин ашигладаг.

Дахин боловсруулалтын үр дүнд гөлтгөнө, хуванцар, замын хавтан, тоосго, гулдмай зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлж тойрог эдийн засагт хувь нэмрээ оруулж байна.

### Таксономи ангилал:

6.2.1 Хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжууд, үйл ажиллагаа

### Хамаарах ТХЗ:



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК

### Компанийн танилцуулга:



“Цэцүүх Трейд” ХХК нь 1996 онд байгуулагдсан, химийн төрөл бүрийн бодис урвалж, бэлдмэл, лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга, шил сав, хүн эмнэлэг, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн ханган нийлүүлэлт, угсралт суурилуулалт, сургалт сурталчилгаа, засвар үйлчилгээ, аюултай ачаа тээвэр, аюултай хаягдал болох химийн хуванцар сав, IBC танк, уут шуудай дахин боловсруулах ЭКО үйлдвэр зэрэг цогц үйл ажиллагааг эрхэлж, салбартаа тэргүүлэн ажиллаж байна. 2017 онд Олон Улсын ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг МУ-д анхдагчаар зэрэг ханган, баталгаажсан гэрчилгээг авч, амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа хамт олон юм.



Химийн хуванцар сав баглаа боодол дахин боловсруулах эко үйлдвэр нь дараах хүчин чадалтай.

Үүнд:

- PP уутыг бутлах угаах - 269.3 тн/жил,
- PE савыг бутлах, угаах - 1,974.7 тн/жил,
- Үрэл үйлдвэрлэх – 1,907.4 тн/жил

Химийн бодисын сав баглаа боодлыг бүрэн дахин боловсруулж, үлдэгдлийг шатаах зууханд шатаадаг. Нам даралтын зуухны үнсийг хог хаягдлын газар гэрээлж устгуулан, усыг бактерийн түвшин хүртэл цэвэршүүлэн дахин ашигладаг зэргээр байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг.

## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Дахин боловсруулах түүхий эд хадгалах агуулах барих, тээвэрлэх ачааны машин худалдан авах зээл

### Таксономи ангилал:

6.2.1 Хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжууд, үйл ажиллагаа

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

### 500ТН

Жилд 500 тн аюултай хуванцар байгальд хаягдахаас сэргийлж байна.



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ПОЛИПАК ХХК

### Компанийн танилцуулга:



*Полипак ХХК*

“Полипак” ХХК нь 2012 онд хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах чиглэлээр үүсгэн байгуулагдсан. Монголдоо хаягдал гялгар уутыг дахин боловсруулж, түүгээрээ бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн анхны үйлдвэрлэгчдийг нэг юм. Тухайн үйлдвэр нь анх байгуулагдахдаа жилд 80 тонн хаягдал уут дахин боловсруулах хүчин чадалтай, хоёр хүн ажилладаг байсан бол 2023 онд үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлж, шинэ үйлдвэртэй болсон ба жилд 400 тонныг дахин боловсруулах хүчин чадалтай, 9 хүнийг тогтвортой ажлын байраар ханган ажиллаж байна. Полипак ХХК нь 100 хувь дахин боловсруулсан хог хаягдлаар төрөл бүрийн багцлагч уут, хими цэвэрлэгээний уут, бариултай тор, хогны уут, хүнсний бус савлагааны уутнуудыг үйлдвэрлэдэг ба бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашигласан усны 75 хувийг дахин ашигладаг, химийн бодис ашиглахгүйгээр тунгаах аргаар түүхий эдийг бохирдлоос салгадаг онцлогтой.

Мөн дахин боловсруулсан түүхий эдээр үйлдвэрлэж буй ахуйн зориулалттай бариултай тор болон хогны уутнууд нь Монгол улсад мөрдөгдөж буй MNS ISO 8367-2:1998 Сав баглаа боодол-Ерөнхий зориулалтын уут стандартын шаардлагыг хангасан тохирлын гэрчилгээтэй.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Тоног төхөөрөмж худалдан авах зээл

Шинэ үйлдвэрийн хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авснаар 5 дахин хог хаягдал боловсруулах хүчин чадалтай болсон.

### Таксономи ангилал:

6.2.2 Хаягдал цуглуулах, ангилах болон нөхөн сэргээх, дахин боловсруулах байгууламжууд

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 400ТН

400 тн хуванцар хаягдлыг хөрсөнд шингэж бохирдол үүсгэхээс сэргийлсэн.





## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА МУЛТИПАК ХХК

### Компанийн танилцуулга:



"Мултипак" ХХК нь 2010 онд үүсгэн байгуулагдсан ба хүнсний скоч болон ахуйн барааны боодлын гялгар хальсыг үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хоёрдогч хальс дахин боловсруулах үйлдвэр нь хог хаягдлын хэмжээг бууруулах зорилгоор ороогч болон багцлагч хальс үйлдвэрлэлийнхээ 30-иас дээш хувийг дахин боловсруулсан түүхий эдээр

орлуулж стандартын шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг.

Дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг харилцагч байгууллагуудын үйлдвэрлэл, үйл ажиллагааны шат дамжлага бүрд ашиглалтаас гарч буй төрөл бүрийн хуванцар хальсыг дахивар цуглуулах цэгүүдээрээ дамжуулан татан авч дахин боловсруулдаг.



Харилцагч нь дахин боловсруулсан түүхий эдээр хийгдсэн багцлагч болон ороогч хальсыг борлуулах зах зээлийн үнэ нь анхдагч түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс 36.4 хувиар хямд үнэтэй байна. Мөн механик шинж чанарыг сайжруулдаг нэмэлт найрлагатай тул бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс 11%-иар илүү бат бөх.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Эргэлтийн хөрөнгийн зээл

### Таксономи ангилал:

6.2.2 Хаягдал цуглуулах, ангилах болон нөхөн сэргээх, дахин боловсруулах байгууламжууд

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

### 80ТН

80 тн хуванцар хаягдлыг хөрсөнд шингэж бохирдол үүсгэхээс сэргийлсэн.



## ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР

### ГОВЬ КҮРҮМА ХХК

#### Компанийн танилцуулга:



"Говь Күрүма" ХХК нь 2010 онд анх үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш нүүрс тээвэр болон гадаад дотоод худалдааны чиглэлээр нийт 52 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор нийт 30ш задгай, 12ш давхар чиргүүл бүхий тээврийн хэрэгслээр Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг.

Нүүрс тээврийн салбарт Монголдоо анхны байгаль орчинд ээлтэй, газар ажилладаг эко тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа явуулж байна. Цэвэр түлш болох LPG ашигласнаар агаарын бохирдол багасаж, нүүрс тээвэрлэгдэж буй орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө буурах, амьсгалын замын өвчлөл зэрэг асуудлуудыг багасгах боломжтой.



## САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ:

### Зээлийн зориулалт:

Шингэрүүлсэн байгалийн хийн хөдөлгүүр бүхий 12 ширхэг тээврийн хэрэгслийг чиргүүлийн хамтаар худалдан авах зээл

### Таксономи ангилал:

8.1.1 Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгсэл худалдан авах

### Хамаарах ТХЗ:



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ:

# 99.94%

CO<sub>2</sub>-ын ялгарлыг бууруулсан хувь

# 0.45тнCO<sub>2</sub>Е

Бууруулах хүлэмжийн хийн хэмжээ (жилд тнCO<sub>2</sub>e) : 0.45тнCO<sub>2</sub>e/машин





ГОЛОМТ БАНКНЫ  
НОГООН ЗЭЭЛИЙН  
ЭХ ҮҮСВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА





Голомт банк тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд, үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын хөрөнгө оруулалтын сангууд болон хөгжлийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг ба сайн сайхныг санхүүжүүлэх зорилгынхоо хүрээнд харилцагч бүрийн бизнес загвар, хэрэгцээнд нийцсэн олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, шийдлийг санал болгосоор ирсэн.

## GLOBAL CLIMATE PARTNERSHIP FUND (GCPF)



Голомт банк Швейцар улсад төвтэй, тогтвортой хөгжлийн хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн responsAbility Investments AG байгууллагаас 15 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн ба тус санхүүжилт нь байгаль орчинд ээлтэй, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжихэд зориулагдах ба нийслэл болон орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд шаардлагатай, зорилтот зээлийн үйлчилгээг хүргэхэд зарцуулагдах юм.

## WATER EQUITY (WE)



Голомт банк тогтвортой хөгжлийг дэмжих, харилцагчдынхаа ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд WaterEquity байгууллагатай хамтран НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 6-р зорилго болох “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламж”-д хамаарах төслүүдэд санхүүжилт татан төвлөрүүлсэн.

Water.org нь дэлхийн олон сая хүний амьдралд баталгаат ус, ариун цэврийн хүртээмжид эерэг нөлөө үзүүлсээр ирсэн олон улсын ашгийн бус байгууллага бөгөөд 2016 онд хөрөнгө удирдлагын WaterEquity-ийг үүсгэн байгуулсан. Тус байгууллага нь зөвхөн хөгжиж буй зах зээлд цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг, салбартаа анхдагч байгууллага юм.



ГОЛОМТ БАНКНЫ НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

## АВТОМАШИНЫ НОГООН ЗЭЭЛ

Хувийн хэрэгцээнд зориулж автомашин авах гэж буй харилцагчдад зориулсан зээлийн бүтээгдэхүүн.

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.



# НОГООН АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ

Ногоон барилгад тусгайлан зориулсан  
зээлийн үйлчилгээ

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.



# НОГООН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

Ногоон бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулсан зээлийн  
бүтээгдэхүүн. • Цахилгаан бараа • Тавилга • Унадаг дугуй • Цахилгаан  
скүүтер гэх мэт

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.





# ХҮҮ ХУВААХ НӨХЦӨЛТЭЙ ТОГТВОРТОЙ, НОГООН БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

Голомт банктай хамтран ажилладаг байгууллагаас бүтээгдэхүүн,  
үйлчилгээ худалдан авч буй бизнес эрхлэгч нарт зориулсан зээл юм

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.



## БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй эсвэл эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүд бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа зарцуулах зориулалтаар авах боломжтой.

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.



# ТОГТВОРТОЙ, НОГООН БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

Бизнесийн үйл ажиллагаандаа Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын хувьд тогтвортой байдлыг нэвтрүүлэх, Байгаль орчинд ээлтэй байхыг зорьж буй Бизнес эрхлэгч Иргэн, Аж ахуй нэгж авах боломжтой.

**QR** УНШУУЛАН ДЭЛГЭРЭНГҮЙ  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.

